

# Уншигч судлаач та бүхэндээ зориулж “Тогтмол хэвлэлийн сан хөмрөгт” буй Орос сэтгүүлийг цувралаар толилуулж байна.

## Агитатор и пропагандист Красной Армии

1942-1946 онд Зөвлөлтийн Улаан армийн Улс төрийн газраас сард 2 удаа эрхлэн хэвлүүлж байсан цэрэг улс төрийн сэтгүүл. Улс төрийн ажилтан, нам, комсомолын идэвхтэн, суртал ухуулагч нарт зориулагдсан уг сэтгүүлд армийн улс төрийн ажилтнуудын гарын авлага, туслах материал, улс төрийн судлалын хөтөлбөр, сэдэв, лекц, яриа хэлэлцүүлгийн төлөвлөгөөг голчлон нийтэлж байв.


1943, 1945 оны дугаарууд



## Агробиология

1935 онд Оросын Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны Академиас эрхлэн гаргажээ. 1935-1941 онд “Яровизация” нэрээр гарч байв. Дайны жилүүдэд буюу 1941-1945 онд тус сэтгүүл гараагүй. 1946 оноос “Агробиология”, 1965 оноос “Сельскохозяйственная биология” нэрээр гарч байгаа Оросын биологи, хөдөө аж ахуйн шинжлэх ухаан-онолын сэтгүүл юм.


1947-1965 оны дугаарууд



## Автогенное дело


1929 онд анхны дугаар гарчээ. 1941-1944, 1953 онд хэвлэгдээгүй. 1953 оноос “Автогенное дело” нэрээр гарч эхэлжээ. Зөвлөлтийн СнЗ-ийн дэргэдэх Шинжлэх ухаан, техникийн Улсын Хороо, Машин механизмын үйлдвэрлэлийн яам, Машин механизмын шинжлэх ухаан, техникийн нийгэмлэгээс хамтран гаргаж сар тутмын шинжлэх ухаан техникийн сэтгүүл. 1959 оноос англи хэл дээрх хувилбар нь гарах болсон.

1939, 1948-1953 он хүртэлх дугаарууд



## Автомобиль


ЗСБНХОУ-ын Авто тээврийн яамнаас эрхлэн гаргаж байсан сэтгүүл. 1943, 1947-1951 оны дугаарууд



## Автомобильная промышленность

1930 онд анхны дугаар нь хэвлэгдэн гарчээ. ЗХУ-ын Автомашин, тракторын үйлдвэрийн яамнаас эрхлэн гаргаж байсан шинжлэх ухаан техникийн сар тутмын сэтгүүл.

1948-1951, 1953-1959, 1962, 1965-1973, 1979-1983, 1991 оны дугаарууд



## Акушерство и гинекология

1922 онд эх барих, эмэгтэйчүүдийн эмч, проф М.А.Губаревын санаачлагаар гарчээ. Анх "Гинекология и акушерство" нэртэй байснаа 1936 онд "Журналом акушерства и женских болезней" сэтгүүлтэй нийлүүлснээр одоогийн нэрээрээ гарчээ. Сэтгүүлийн нийтлэлүүд нь шинжлэх ухааны өндөр түвшинд бичигддэг, гадаад, дотоодын мэргэжилтнүүдийн хүлээн зөвшөөрсөн сэтгүүл болсон. Тус сэтгүүл одоо ч хэвлэгдэн гарсаар байна. 1939, 1941, 1947, 1949-1965, 1967-1991 оны дугаарууд

## Архив патологии

Уг сэтгүүлийн анхны дугаар 1935 онд гарчээ. ЗХУ-ын Анагаах ухааны Академиас эрхлэн гаргаж байсан энэ сэтгүүл орос хэл дээрх хамгийн эртний эрүүл мэндийн тогтмол хэвлэлийн нэг гэж тооцогддог. Энд эмгэг анатоми, ерөнхий эмгэг болон сэдэвчилсэн асуудлаар анхны судалгаа, туршилтын талаар голлон нийтэлж байв.

1949-1975 оны дугаарууд



## Библиография


Ном зүй судлалын талаарх Оросын номын танхимийн мэргэжлийн тэмдэглэл. 1929 онд анх Москвад хэвлэгдсэн. Ном зүй, түүний онол, арга зүй, номзүйн үйл ажиллагааны зохион байгуулалт, туршлага дээр үндэслэсэн нийтлэлийг голчлон хэвлэдэг. 1930 оноос "Библиотекосведение и библиография", 1933 оноос "Советская библиография", 1992 оноос

“Библиография” нэрээр хэвлэгдсэн. 1959 оноос жилд 6 удаа гарах болсон. 1929, 1990-2008 оны дугаарууд

## Борьба классов

1931 оноос Москва хотноо хэвлэгдэж байсан нийтэд зориулсан шинжлэх ухаан түүхийн сэтгүүл. Сэтгүүлд ЗХУ болон бусад орнуудын хувьсгалт хөдөлгөөн, Коминтерн, БХК(б)Н-ын түүхийн талаарх материалыг нийтэлж байв. 1937 оноос хойш "Исторический журнал" нэртэй гарчээ.

1931, 1934-1936 оны дугаарууд



## Большевик

БХК(б)Н-ын Төв Хорооны улс төр, онолын сэтгүүл. 1924 оны 4-р сараас эхлэн гарч эхэлсэн бөгөөд 14 хоногт 1 удаа хэвлэгдэж байв. Сэтгүүлд марксизм, ленинизмын онолын асуудлууд, олон улсын коммунист хөдөлгөөний түүх, ЗХУ дахь коммунизмыг байгуулж буй бүтээн байгуулалтын асуудлыг хөндсөн гүн ухаан, эдийн засаг, утга зохиол соёлын нийтлэлийг хэвлэдэг байв. 1924-1927., 1930-1952 оны дугаарууд